

 ГРИЙН ХИМИСТРИ ХХК	ЁС ЗҮЙН ДҮРЭМ		Дугаар:2024/53
ГРИЙН ХИМИСТРИ ХХК	Хувилбар: 3	Эх хувь Хувилалт №	Хуудас 1 нийт 3

КОМПАНИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Дүрмийн зорилго, хэрэгжилт, хамрах тал, товчилсон нэр

2. ХАМРАХ ХҮРЭЭ

2. Энэхүү дүрмийг компанийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан, бусад ажилтнууд болон болон хамтран ажиллагч талууд заавал дагаж мөрдөнө.

3. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЁС ЗҮЙН ЗАРЧИМ

3.1 Нийтлэг ёс зүйн хэм хэмжээ

3.2 Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүний ёс зүйн хэм хэмжээ

3.3 Гүйцэтгэх удирдлагын ёс зүйн хэм хэмжээ

3.4 Ажилтны нийтлэг ёс зүйн хэм хэмжээ

4. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

БАТАЛСАН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ДАВААЦЭРЭН



ГРИЙН ХИМИСТРИ ХХК

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

ГРИЙН ХИМИСТРИ ХХК

Хувилбар: 3

Эх хувь
Хувилалт №

Дугаар:2024/53

GREEN
CHEMISTRY
LLC

Хуудас 2 нийт 3

УЛААНБААТАР ХОТ
ТТГ6939-3640954

КОМПАНИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. "Грийн Химистри" ХХК /цаашид "компани" гэх/ нь шударга ёс, хариуцлагатай үйл ажиллагааг эрхэмлэн, бизнесийн ёс зүйг чанд баримтлан ажилладаг. Энэхүү ёс зүйн дүрэм нь компанийн ажилтнууд, удирдлагууд болон хамтран ажиллагч талуудын дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг тодорхойлох зорилготой.
- 1.2. Энэхүү ёс зүйн дүрмийн зорилго нь "Грийн химистри" ХХК-ийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан, бусад ажилтнууд болон хамтран ажиллагч талуудын үйл ажиллагаандаа баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тогтоож, түүнийг мөрдүүлэх, хэвшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.3. Дүрэмд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 1.3.1. "компанийн ашиг сонирхол" гэж компанийн бодлогын баримт бичиг, хөтөлбөр, дүрэм, журам, шийдвэрт нийцсэн эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг;
 - 1.3.2. "хувийн ашиг сонирхол" гэж албан үүргээ гүйцэтгэхдээ өөрөө болон хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг;
 - 1.3.3. давуу байдал" гэж нэр төр, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд бий болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;
 - 1.3.4. "эрх бүхий албан тушаалтан" гэж төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/-ийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, компаниас заасан бусад албан тушаалтныг;

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. Энэхүү дүрмийг компанийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан, бусад ажилтнууд болон болон хамтран ажиллагч талууд заавал дагаж мөрдөнө.

ГУРАВ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЁС ЗҮЙН ЗАРЧИМ

- 3.1. Компанийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан, бусад ажилтнууд болон хамтран ажиллагч талууд нь ажил, үүрэг гүйцэтгэхдээ холбогдох хууль, тогтоомж, энэхүү дүрэм болон дараах ёс зүйн хэм хэмжээ, зарчмыг баримтлан ажиллана. Үүнд:
 - 3.1.1. Үйл ажиллагаандаа хууль тогтоомж, дүрэм, журмыг чандлан мөрдөх;
 - 3.1.2. Үйл ажиллагаагаа шударга, ил тод, нээлттэй байдлаар явуулах;
 - 3.1.3. Авилга, хээл хахуулиас ангид байх;
 - 3.1.4. Харилцагч түншүүдтэй шударга, хариуцлагатай харилцах;
 - 3.1.5. Хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагч, харилцагч, бэлтгэн нийлүүлэгч, хэрэглэгч, ажилтнууд зэрэг оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэх;
 - 3.1.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг эрхэмлэх;
 - 3.1.7. Ажилтан бүрд эрх тэгш, хүндэтгэлтэй хандан аюулгүй байдалд ажиллах орчныг бүрдүүлэх;
 - 3.1.8. Олон талт оролцоо, багийн ажиллагааг хөгжүүлсэн харилцан итгэлцэл, хүндлэл бүхий хамтын ажиллагааг эрхэмлэх;
 - 3.1.9. Улс төрийн зорилготой хандив өгөхөөс зайлсхийх;
 - 3.1.10. Компанийн нэр хүнд, өмч хөрөнгийг хамгаалах;
 - 3.1.11. Компанийн нууц болон үйл ажиллагааныхаа дагуу олж мэдсэн хувь хүний нууцыг холбогдох хуульд заасны дагуу хамгаалах;
 - 3.1.12. Хүүхдийн хөдөлмөрийг ашиглахыг бүрэн хориглох;
 - 3.1.13. Ямарваа нэгэн дарамт, ялгарварлан гадуурхалт гаргахгүй байх;
 - 3.1.14. Компанийн нэрийн өмнөөс хийгдэх хандив нь хуулийн хүрээнд, ил тод байх;
 - 3.1.15. Буяны хандив нь компанийн нийгмийн хариуцлагын бодлоготой нийцсэн байх;
 - 3.1.16. Бизнес аялал, уулзалт, хүлээн авалтыг компанийн бодлого, стандартын дагуу зохион байгуулах;
 - 3.1.17. Бэлэг, хөнгөлөлт, зочлолтод компанийн ашиг сонирхлыг хохироохгүй байх;
 - 3.1.18. Хэт их үнэ бүхий бэлэг, хүндэтгэлийн зардлыг хязгаарлах;
 - 3.1.19. Компанийн өмч хөрөнгийг зориулалтын дагуу ариг гамтай ашиглах;



ГРИЙН ХИМИСТРИ ХХК

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Хувилбар: 3

Эх хувь

Хувилалт №

ГРИЙН ХИМИСТРИ ХХК

Дугаар: 2024/53

GREEN
CHEMISTRY
LLC

Хуудас 3 нийт 3

УЛААНБААТАР ХОТ
ТТГ6939-А 5640954

3.2. Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүний ёс зүйн хэм хэмжээ:

- 3.2.1. Хууль тогтоомж, хувьцаа эзэмшигчдийн хурал, компанийн дүрэм болон ТУЗ-ийн шийдвэрээр тогтоосон эрх, үүргээ энэхүү дүрэмд заасан ёс зүйн зарчимд бүрэн нийцүүлэх;
- 3.2.2. Компанийн соёлыг хөгжүүлэх;
- 3.2.3. хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, компанийн бусад ажилтнуудын эрх ашгийг хангах;
- 3.2.4. Компанийн аливаа шийдвэр, үйл ажиллагаанд хувийн сонирхлоор хандахгүй, албан тушаалын давуу байдал үүсгэхгүй байх, энэхүү дүрмийг зөрчих үйлдэл, эс үйлдлээс татгалзах, шаардлагатай тохиолдолд бүрэн эрхээсээ татгалзах ёс зүйтэй байх;
- 3.2.5. Бусдад хүндлэлтэй хандах;
- 3.2.6. Дотоод мэдээллийг хууль бусаар ашиглахгүй, задруулахгүй байх;
- 3.2.7. Эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ хичээл зүтгэл гаргаж ажиллах;
- 3.2.8. Ажилтнуудыг хөгжих, сургах боломжийг олгох;
- 3.2.9. Аливаа асуудалд үндэслэлтэй, шударга хандах;

3.3. Гүйцэтгэх удирдлагын ёс зүйн хэм хэмжээ:

- 3.3.1. Компанийн дүрэм, журам, гэрээнд заасан эрх үүргээ хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжийг баримтлах;
- 3.3.2. Ажилтны саналыг сонсож, харилцан уялдаа бүхий эргэх холбоотой ажиллах;
- 3.3.3. компанийн нэрийн өмнөөс оролцогчидтой харилцахдаа ёс зүйн хэм хэмжээг чанд сахих;
- 3.3.4. Албан үүргээ гүйцэтгэхдээ хамт олонтойгоо эелдэг, тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй хандах;
- 3.3.5. Өөрийн буруутай үйл ажиллагааны хариуцлагыг шударгаар хүлээж, дахин давтахгүй, шаардлагатай тохиолдолд албан тушаалаасаа татгалзах ёс зүйтэй байх;
- 3.3.6. Аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлыг орчинг бүрдүүлэх;
- 3.3.7. Энэ дүрмийг зөрчсөн аливаа үйлдэлтэй үл эвлэрч, өөрийн болон бусдын алдаа, дутагдлыг илрүүлэн засаж, ажиллахыг эрмэлзэх.

3.4. Ажилтны нийтлэг ёс зүйн хэм хэмжээ:

- 3.4.1. Хууль тогтоомж, компанийн дүрэм, дотоод журмыг чанд баримталж, компанийн нэр хүндийг дээдлэх;
- 3.4.2. Өөрийн мэдлэг, чадварыг байнга хөгжүүлж, үүрэгт ажлаа мэргэжлийн түвшинд үнэнч шударгаар хариуцлагатай гүйцэтгэж, ажилдаа хүндэтгэлтэй хандах;
- 3.4.3. Хувь хүн, албан байгууллагаас зөвшөөрөгдсөн буюу мөнгөн хэлбэрийн бус, үүрэг хариуцлага, хүлээлт, найдлага шаардаагүй, нээлттэй, ердийн байдлаар хаяглагдсанаас бусад бэлэг хүлээн авах.

ДӨРӨВ.ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

- 4.1. Аливаа этгээд нь ёс зүйн дүрэм зөрчсөн, зөрчиж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдлийг удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд нэн даруй мэдэгдэж, шүгэл үлээгч байна.
- 4.2. Компанийн ажилтны гаргасан зөрчил, хохирлын хэмжээг харгалзан гүйцэтгэх захирлын тушаалаар ажилтанд Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын шийтгэл оногдуулна.
- 4.3. Гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн гишүүнтэй холбоотой ёс зүйн зөрчлийг ТУЗ-ийн хурлын тогтоолоор холбогдох шийтгэлийг оногдуулна. Шаардлагатай тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.
- 4.4. Ёс зүйн дүрэм зөрчиж, зөрчил гаргасан нь гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлэх эрхтэй.
- 4.5. Ёс зүйн дүрэм зөрчиж, зөрчил гаргаж, шийтгэл хүлээсэн өдрөөс хойш нэг жилийн хугацаанд зөрчилтөйд тооцно.